

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН
2011 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2012.02.06

Улаанбаатар хот

**НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ**

2011 онд нийт 32 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 19 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 195 ББСБ-ын санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдсан бөгөөд 2006 оны жилийн эцсийн тайлант хугацаанаас хойш ББСБ-уудын тоонд дараах өөрчлөлт орсон байна.


/Хүснэгт 1/

№	Тайлант хугацаа	Тусгай зөвшөөрөл олгосон	Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	Тайлант хугацааны эцэс дэх ББСБ-ын тоо
1	2006 он	2	24	139
2	2007 он	10	12	137
3	2008 он	10	15	132
4	2009 он	56	11	177
5	2010 он	20	15	182
6	2011 он	32	19	195

Хорооны хуралдааны шийдвэрээр 2011 онд 19 ББСБ-ын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 14 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх арга хэмжээ авч, 8 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлснийг сэргээсэн байна.

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоог өмнөх онуудтай харьцуулвал:

/График 1/



Өмнөх оны жилийн эцсийн голлох статистик үзүүлэлтүүдийг 2011 оны жилийн эцсийн тайлант хугацааны байдалтай харуулбал: Үүнд

/Хүснэгт 2/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2010 оны IV улирал	2011 оны IV улирал	Өсөлт +/-, бууралт -/-
1	ББСБ-ын тоо	182	195	13
2	Хувь нийлүүлэгчдийн тоо	582	602	20
3	Ажиллагсадын тоо	880	1,057	177
4	Салбар нэгжийн тоо	63	64	1
5	Харилцагчдын тоо	158,510	192,577	34,067
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	128,606,250.3	205,409,535.1	76,803,284.8
	Банкны салбарт эзлэх хувь	2.06%	2.19%	0.1%

7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	78,085,816.6	119,004,471.9	40,918,655.3
Банкны салбарт эзлэх хувь		2.42%	2.13%	-0.3%
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	91,961,546.2	138,182,359.6	46,220,813.4
Банкны салбарт эзлэх хувь		24.04%	20.41%	-3.6%
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	80,014,795.6	116,519,924.0	36,505,128.4
Банкны салбарт эзлэх хувь		32.97%	44.11%	11.15%
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	6,211,906.1	14,844,608.6	8,632,703
11	Нийт орлого /мянган төгрөгөөр/	30,102,545.6	46,348,113.1	16,245,567.5
12	Нийт зардал /мянган төгрөгөөр/	22,970,109.4	34,966,902.5	11,996,793.1
13	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	7,132,436.2	11,381,210.6	4,248,774.4
1	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	15	17	2
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		8.24%	8.72%	0.5%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	23,566,259.4	35,443,995.8	11,877,736.5
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		18.32%	17.26%	-1.1%
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	17,393,222.2	21,026,423.8	3,633,201.6
ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь		22.27%	17.67%	-4.6%
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	10,819,241.9	22,249,301.9	11,430,060.0
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		11.76%	16.10%	4.3%
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	10,797,667.0	18,921,432.5	8,123,765.5
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		13.49%	16.24%	2.7%
2	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	26	23	-3
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		14.29%	11.79%	-2.5%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	4,230,401.8	4,791,024.0	560,622.2
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		3.29%	2.33%	-1.0%
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	5,292,775.1	3,714,051.5	(1,578,723.6)
ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь		6.78%	3.12%	-3.7%
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	4,013,977.8	4,606,967.3	592,989.5
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		4.36%	3.33%	-1.0%
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	3,752,952.2	3,428,621.6	(324,330.6)
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		4.69%	2.94%	-1.7%
3	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	48	39	-9
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		26.37%	20.00%	-6.4%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	6,308,654.1	6,506,229.5	197,575.4
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		4.91%	3.17%	-1.7%
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	5,886,669.5	6,461,257.6	574,588.1
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		6.40%	4.68%	-1.7%
В	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	5,115,993.4	5,299,942.4	183,949.0

ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь	6.39%	4.55%	-1.8%
---	--------------	--------------	--------------

Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:

2011 оны жилийн эцсийн байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 17 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 8.7 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 17.3 хувийг, нийт олгосон зээл нь нийт ББСБ-уудын олгосон зээлийн 17.7 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчийн өмчийн 16.1 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 16.2 хувийг тус тус эзэлж байна.

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяаллаар нь авч үзвэл Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1, Япон улсын хөрөнгө оруулалттай 9, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 4, Итали, ОХУ, БНХАУ-ын хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

2011 оны жилийн эцсийн байдлаар орон нутагт төвтэй 23 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 11.8 хувийг, тэдгээрийн нийт актив нь нийт ББСБ-ын активын 2.3 хувийг, нийт олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив нь нийт ББСБ-ын 3.1 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 3.3 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 2.9 хувийг тус тус эзэлж байна. Үүнд:

/График 2/



Валютын арилжааны үйл ажиллагаа дангаар эрхлэн явуулж буй ББСБ:

Валютын арилжаа дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 39 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 20.0 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 3.2 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 4.7 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 4.6 хувийг тус тус эзэлж байна.

ББСБ-уудыг Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж буйгаар нь ангилвал:

/Хүснэгт 3/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо	
		2010 оны IV улирал	2011 оны IV улирал
1	Зээл	134	153
2	Факторингийн үйлчилгээ	8	11
3	Төлбөрийн баталгаа гаргах	6	8

4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5	5
6	Гадаад валютын арилжаа	96	92
7	Итгэлцлийн үйлчилгээ	10	16
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	1	2
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	9	16
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	0	0
11	Хөрөнгө оруулалтын үйлчилгээ ¹ /Венчур хөрөнгө оруулалт/	1	1

2011 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд 10 ББСБ буюу нийт ББСБ-ын 5.1 хувь нь эхлэлтийн санхүүгийн тайлангаар, 2 ББСБ буюу нийт ББСБ-ын 1.0 хувь нь өмнөх үеүдийн санхүүгийн тайлангийн дүнгээр хамрагдлаа.

2011 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар тайлан ирүүлбэл зохих нийт 195 ББСБ-аас 185 ББСБ тайлангаа ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж 2012 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 178 ББСБ-д тайлангийн хариуг хүргүүлсэн байна.

ХОЁР. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Активын бүтэц, өөрчлөлт:

Тайлант жилд нийт ББСБ-уудын активын бүтэц өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 4/

№	ХӨРӨНГӨ	2010.12.31		2011.12.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Эргэлтийн хөрөнгө	123,376,635.2	95.9%	197,694,120.3	96.2%	74,317,485.1	60.2%
1	Мөнгөн хөрөнгө	38,234,867.6	29.7%	64,219,136.7	31.3%	25,984,269.2	68.0%
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	1,766,523.8	1.4%	3,264,637.9	1.6%	1,498,114.1	84.8%
3	Нийт зээл	78,085,816.6	60.7%	119,004,471.9	57.9%	40,918,655.3	52.4%
	(Зээлийн эрсдлийн сан)	3,687,308.5	2.9%	3,791,987.3	1.8%	104,678.8	2.8%
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	1,904,127.3	1.5%	673,590.4	0.3%	-1,230,536.9	-64.6%
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
5	Нийт факторингийн тооцооны авлага	123,448.2	0.1%	2,987,315.0	1.5%	2,863,866.8	2319.9%
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	689,437.0	0.5%	552,657.3	0.3%	-136,779.7	-19.8%
7	Бусад хөрөнгө	6,259,723.2	4.9%	6,734,825.4	3.3%	475,102.2	7.6%
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн авлага	0.0	0.0%	4,049,473.0	2.0%	4,049,473.0	100.0%
Б	Эргэлтийн бус хөрөнгө	5,229,615.1	4.1%	7,715,414.8	3.8%	2,485,799.7	47.5%
9	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	5,229,615.1	4.1%	7,715,414.8	3.8%	2,485,799.7	47.5%
	Үндсэн /биет/ ба биет бус	6,820,027.1	5.3%	9,770,929.3	4.8%	2,950,902.2	43.3%

¹ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны хуульд заагдсан тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамаарахгүй бөгөөд Хорооны 2009 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 185 дугаар тогтоолоор батлагдсан "Банк бус санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэх түр журам"-ыг үндэслэн Эн Ви Си ББСБ-д уг үйлчилгээг эрхлэх зөвшөөрлийг олгосон.

хөрөнгө						
(Хуримтлагдсан элэгдэл)	1,590,412.0	1.2%	2,055,514.5	1.0%	465,102.6	29.2%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	128,606,250.3	100.0%	205,409,535.1	100.0%	76,803,284.8	59.7%

ББСБ-ын 2011 оны нийт актив өмнөх оны мөн үеэс 59.7 хувиар өсөхөд хуримтлагдсан ашиг, нийт өр төлбөр, дүрмийн сангийн /хувьцаат капитал/ өсөлтүүд гол нөлөөг үзүүлсэн байна.

Тайлант хугацаанд нийт активын 57.9 хувийг зээл, 31.3 хувийг мөнгөн хөрөнгө эзэлж байгаа нь нийт активын 89.2 хувь болж байна.

2.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 5/

№	Ангилал	2010.12.31		2011.12.31		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
1	Хэвийн	70,700,950.6	90.5%	111,368,770.4	93.6%	40,667,819.8	57.5%
2	Хугацаа хэтэрсэн	2,647,890.2	3.4%	1,509,662.1	1.3%	-1,138,228.1	-43.0%
3	Чанаргүй зээл. Үүнээс	4,736,975.8	6.1%	6,126,039.4	5.1%	1,389,063.6	29.3%
	Хэвийн бус	916,945.3	1.2%	1,809,571.2	1.5%	892,626.0	97.3%
	Эргэлзээтэй	924,077.2	1.2%	1,238,029.1	1.0%	313,951.8	34.0%
	Муу	2,895,953.3	3.7%	3,078,439.1	2.6%	182,485.7	6.3%
	(Зээлийн эрсдлийн сан)	3,687,308.5	4.7%	3,791,987.3	3.2%	104,678.8	2.8%
	Нийт зээл	78,085,816.6	100 %	119,004,471.9	100 %	40,918,655.3	52.4%

2011 оны жилийн эцсийн зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, нийт зээлийн багц 52.4 хувиар өссөнөөс зээлийн багцад эзлэх хувийн жингээр хэвийн зээл 57.5 хувиар, чанаргүй зээл 29.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт зээлийн хэмжээ 40,918,655.3 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотойгоор чанаргүй зээлийн хэмжээ 1,389,063.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн мэт харагдаж буй боловч нийт зээлийн дүнд эзлэх чанаргүй зээлийн хувь 5.1 хувь болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.0 хувиар буурч чанаржсан эерэг үзүүлэлттэй байна.


2.3 Зээлийн хүү:

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 195 ББСБ-аас 78,5 хувь буюу 153 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудын зээлийн сарын хамгийн дээд хүү 10 хувь, хамгийн бага хүү 0.4 хувь байна.

Арифметик энгийн дунджаар тооцож үзвэл, нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж дээд хүү 3.8 хувь, зээлийн дундаж доод хүү 2.1 хувь буюу нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү 2.9 хувь байна.

ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал дараах байдалтай байна.


/График 3/



2.4 Активын үзүүлэлтүүдийн харьцуулсан судалгаа:


ББСБ-уудын нийт активын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 4/



ББСБ-уудын нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.

/График 5/



/График 6/



Графикаас үзэхэд зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь 2009 онд хамгийн өндөр үзүүлэлттэй байна

ГУРАВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

ББСБ-уудын 2011 оны тайлант хугацааны нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх онтой харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

/Хүснэгт 6/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2010.12.31		2011.12.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Өр төлбөр	30,427,530.3	23.7%	54,217,683.3	26.4%	23,790,153.0	78.2%
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	6,211,906.1	4.8%	14,844,608.6	7.2%	8,632,702.6	139.0%
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	19,585,495.7	15.2%	33,030,104.9	16.1%	13,444,609.3	68.6%
3	Бусад эх үүсвэр	435,232.5	0.3%	1,973,783.5	1.0%	1,538,551.0	353.5%
	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	428,526.2	0.3%	1,973,783.5	1.0%	1,545,257.3	360.6%
	Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг	3,007.0	0.0%	0.0	0.0%	-3,007.0	-100%
	Факторингийн үйлчилгээний өглөг	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0
	Гадаад валютын арилжааны эх үүсвэр	3,699.4	0.0%	0.0	0.0%	-3,699.4	-100%
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	400,000.0	0.3%	0.0	0.0%	-400,000.0	-100%
5	Төслийн зээлийн санхүүжилт	3,794,896.1	3.0%	4,369,186.3	2.1%	574,290.2	15.1%
	Бусад өр төлбөр	6,217,173.8	4.8%	13,009,492.2	6.3%	6,792,318.4	109 %
6	Хуримтлууулж тооцсон хүүгийн өглөг	1,058,993.5	0.8%	2,095,721.8	1.0%	1,036,728.2	97.9%
7	Бусад пассив	5,158,180.2	4.0%	6,868,125.4	3.3%	1,709,945.2	33.2%
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	0.0	0.0%	4,045,645.0	2.0%	4,045,645.0	100%
	Нийт өр төлбөр	36,644,704.1	28.5%	67,227,175.5	32.7%	30,582,471.4	83.5%
Б	Эзэмшигчдийн өмч	91,961,546.2	71.5%	138,182,359.6	67.3%	46,220,813.4	50.3%
9	Хувьцаат капитал	80,014,795.6	62.2%	116,519,924.0	56.7%	36,505,128.4	45.6%
10	Бусад өмч	519,908.4	0.4%	3,189,400.2	1.6%	2,669,491.7	513.5%
11	Сангууд	1,122,224.7	0.9%	1,122,754.7	0.5%	530.0	0.0%
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	9,381,384.2	7.3%	14,681,605.6	7.1%	5,300,221.4	56.5%
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	923,233.4	0.7%	2,668,675.1	1.3%	1,745,441.8	189.1%
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	128,606,250.3	100%	205,409,535.1	100%	76,803,284.8	59.7%

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 83.5 хувиар, эзэмшигчдийн өмч 50.3 хувиар тус тус өссөн байна.

2010 оны жилийн эцсийн тайлангаар нийт эх үүсвэрийн 28.5 хувийг нийт өр төлбөр, 71.5 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2011 оны жилийн эцэст нийт өр төлбөр 32.7 хувь, эзэмшигчийн өмч 67.3 хувь болж өөрчлөгдсөн байна. Эх үүсвэрт эзлэх нийт өр төлбөр өссөн гол шалтгаан нь ББСБ-уудын итгэлцлийн үйлчилгээний өглөг, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хэмжээ өссөнтэй холбоотой.


Өөрийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдсэн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлын хувьд эерэг үзүүлэлт болж байна.

Дүрмийн сангийн өсөлтөд Хорооны 2008 “Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 169 дүгээр тогтоолоор үүрэг болгосны дагуу ББСБ-ууд дүрмийн санг нэмэгдүүлсэн нь голлох үүрэг гүйцэтгэсэн.


Мөн банк бус санхүүгийн байгууллага шинээр нэмэгдэж иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх сонирхол нэмэгдсэнтэйгээр дүрмийн сан өсч байна.

ББСБ-уудын системийн нийт пассивын голлох үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 7/



/График 8/



ДӨРӨВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

ББСБ-уудын 2011 оны жилийн эцсийн байдлаар нийт орлого өмнөх оны мөн үеэс 54 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

/Хүснэгт 7/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.12.31		2011.12.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	ХҮҮГИЙН ОРЛОГО	20,676,621.2	68.7	30,331,494.1	65.4	9,654,872.9	46.7

	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	19,018,221.9	63.2	28,066,043.2	60.6	9,047,821.4	47.6
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	1,065,450.5	3.5	662,009.6	1.4	-403,440.8	-37.9
	Үнэт цаасны хүүгийн орлого	61,156.0	0.2	0.0	0.0	-61,156.0	-100
	Бусад хүүгийн орлого	531,792.9	1.8	1,603,441.2	3.5	1,071,648.3	201.5
2	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	8,416,589.6	28.0	15,233,947.4	32.9	6,817,357.8	81.0
3	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	986,638.7	3.3	776,368.3	1.7	-210,270.4	-21.3
4	ЕРДИЙН БУС ОРЛОГО	22,696.1	0.1	6,303.3	0.0	-16,392.8	-72.2
	НИЙТ ОРЛОГО	30,102,545.6	100.0	46,348,113.1	100.0	16,245,567.5	54.0

2011 оны оны жилийн эцсийн орлого өмнөх оны мөн үеэс 54 хувиар өссөн нь ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн өсөлт, бусдаас татсан эх үүсвэрийн өсөлт зэрэг нь үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлж улмаар үндсэн үйл ажиллагааны орлого болох хүүгийн орлогын өсөлтөд эерэгээр нөлөөлсөн байна.

Тайлант хугацааны нийт орлогын 65.4 хувийг хүүгийн орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн орлогын дүнтэй харьцуулахад 46.7 хувиар өссөн/, 32.9 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн бус орлогын дүнтэй харьцуулахад 81.0 хувиар өссөн/ эзэлж байна.

Хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс 81.0 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

/Хүснэгт 8/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.12.31		2011.12.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Арилжааны орлого	2,594,686.2	30.8	5,848,252.0	38.4	3,253,565.8	125.4
1.1	Гадаад валютын арилжааны орлого	2,594,686.2	30.8	5,205,557.5	34.2	2,610,871.2	100.6
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	0.0	0.0	642,694.6	4.2	642,694.6	100
2	Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	4,061,764.1	48.3	6,577,226.0	43.2	2,515,461.9	61.9
2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	4,061,764.1	48.3	6,555,132.3	43.0	2,493,368.2	61.4
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	0.0	0.0	22,093.7	0.1	22,093.7	0.0
3	Санхүүгийн үйлчилгээний орлого	1,760,139.3	20.9	2,808,469.4	18.4	1,048,330.1	59.6
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	351.0	0.0	6,890.6	0.0	6,539.5	1862
3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	1,115.9	0.0	2,032.1	0.0	916.1	82.1
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	645,627.5	7.7	738,727.2	4.8	93,099.7	14.4
3.4	Картын үйлчилгээний орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	68,358.7	0.8	91,555.4	0.6	23,196.6	33.9
3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	739,640.7	8.8	1,425,885.4	9.4	686,244.8	92.8
3.7	Бусад	305,045.4	3.6	543,378.7	3.6	238,333.3	78.1
	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО НИЙТ	8,416,589.6	100.0	15,233,947.4	100.0	6,817,357.8	81.0

2010 оны жилийн эцсийн байдлаар нийт хүүгийн бус орлогын 30.8 хувийг гадаад валютын арилжааны орлого, 48.3 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 20.9 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байсан бол 2011 оны жилийн эцсийн байдлаар нийт

хүүгийн бус орлогын 38.4 хувийг гадаад валютын арилжааны орлого, 43.2 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 18.4 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байна.

Нийт зардлын бүтэц дараах байдалтай байна.

/Хүснэгт 9/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.12.31		2011.12.31		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	2,394,449.9	10.4	5,098,832.7	14.6	2,704,382.8	112.9
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	16,984,728.2	73.9	25,603,893.3	73.2	8,619,165.1	50.7
3	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	2,247,029.4	9.8	2,114,666.7	6.0	-132,362.7	-5.9
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	387,168.8	1.7	636,885.0	1.8	249,716.2	64.5
5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	12,632.8	0.1	17,828.4	0.1	5,195.6	41.1
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	944,100.4	4.1	1,494,796.4	4.3	550,696.0	58.3
	НИЙТ ЗАРДАЛ	22,970,109.4	100.0	34,966,902.5	100.0	11,996,793.1	52.2

2011 оны жилийн эцсийн байдлаар нийт зардал өмнөх оны мөн үеэс 52.2 хувиар өссөнөөс хүүгийн зардал 112.9 хувиар, хүүгийн бус зардал 50.7 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардал 64.5 хувиар, орлогын татварын зардал 58.3 хувиар тус тус өссөн.

Харин болзошгүй эрсдэлийн зардал 5.9 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь зээлийн чанар сайжирсантай холбоотой эерэг нөлөөг бий болгосон байна.

ББСБ-ын 2011 оны жилийн эцсийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 54.0 хувиар, нийт зардал 52.2 хувиар тус тус өссөн байна.

2011 оны жилийн эцсийн байдлаар нийт 11,381,210.6 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 59.6 хувиар өссөн байна.

/Хүснэгт 10/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.12.31	2011.12.31	Өөрчлөлт
		Дүн	Дүн	Дүн
1	НИЙТ ОРЛОГО	30,102,545.6	46,348,113.1	16,245,567.5
2	НИЙТ ЗАРДАЛ	22,970,109.4	34,966,902.5	11,996,793.1
3	ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ	7,132,436.2	11,381,210.6	4,248,774.4

ББСБ-уудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

/График 9/



Өмнөх онтой харьцуулахад системийн хувьд нийт ашиг нэмэгдсэн нь ББСБ-уудын активын өсөлт, ББСБ-ын тооны өсөлт тэдгээрийн үйл ажиллагааны үр ашиг нэмэгдсэн байна.

Тайлант жилд 168 ББСБ буюу нийт ББСБ-ын 86.2 хувь нь ямар нэг хэмжээгээр ашигтай ажилласан ба тэдгээрийн нийт ашиг 13,915,991.9 мянган төгрөг байна. Ашигтай ажилласан ББСБ-уудын ашгийн арифметик дундаж ашиг 82,833.1 мянган төгрөг байна.

Харин нийт ББСБ-уудын 8.2 хувь буюу 16 ББСБ 2,534,781.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан.

ТАВ. БҮЛГИЙН САНХҮҮГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийт ББСБ-уудыг активын хэмжээгээр нь 400,000.0 мянган төгрөг хүртэл активтай 400,000.0 мянган төгрөгөөс 1,000,000.0 мянган төгрөг хүртэл активтай, 1,000,000.0 мянган төгрөг ба түүнээс дээш төгрөгийн активтай мөн зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ гэсэн 4 бүлэгт хуваан тооцов.

2011 оны жилийн эцсийн байдлаарх бүлгүүдийн бүтэц дараах байдалтай байна:

/Хүснэгт 11/

№	Бүлэг	Бүлэгт хамаарах ББСБ-ын тоо	Бүлгийн нийт актив		Нэмэлт мэдээлэл
			Актив /мянган төгрөг/	Нийт активт эзлэх хэмжээ /хувь/	
1	Бүлэг 01	39	148,037,970.8	72.1	1,000,000.0 мянган төгрөгөөс дээш хэмжээний активтай
2	Бүлэг 02	95	48,736,587.8	23.7	400,000.0 мянган төгрөгөөс 1,000,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай
3	Бүлэг 03	22	2,128,747.0	1.1	400,000.0 мянган төгрөг хүртэл хэмжээний активтай
4	Бүлэг 04	39	6,506,229.5	3.1	Зөвхөн гадаад валютын арилжаа эрхэлдэг.
НИЙТ		195	205,409,535.1	100.0	

2011 оны жилийн эцсийн байдлаарх бүлгүүдийн тайлант үеийн ашиг дараах байдалтай байна. Үүнд:

/Хүснэгт 12/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Ашиг	Салбарын нийт татварын дараах цэвэр ашигт эзлэх хувь
1	Бүлэг 01	7,710,811.5	67.7
2	Бүлэг 02	3,277,360.0	28.8
3	Бүлэг 03	-100,782.4	-0.8
4	Бүлэг 04	493,821.6	4.3

НИЙТ	11,381,210.6	100.0
-------------	---------------------	--------------

Бүлгүүдийн актив, ашгийн үзүүлэлтүүдийг харахад “Бүлэг 01”-д хамаарах 39 ББСБ /нийт ББСБ-ын 20 хувь/ нь бүхий л үзүүлэлтүүдээр голлох байр суурийг эзэлж байна.

ЗУРГАА. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ББСБ-ын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 138,182,359.6 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 138,970,847.6 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын хувьд 97.1 хувь, өөрийн хөрөнгийн хувьд 99.5 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 65.7 хувь;

- түргэн борлогдох актив 66,973,960.5 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 46,177,548.7 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 145.0 хувь;

- валютын дансны цэвэр зөрүү 4,619,399.4 мянган төгрөг, тухайн валютаарх өөрийн хөрөнгө 138,182,359.6 мянган төгрөг байгаагаас нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 3.34 хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 14,844,608.6 мянган төгрөг, хувьцаат капитал 116,519,924.0 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын харьцаа 12.7 хувь;

- нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 2,593,892.1 мянган төгрөг, нийт актив 205,409,535.1 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.3 хувь байгаа нь зохистой харьцааны үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

Харин активын эрсдэлийн санг 4,510,285.9 мянган төгрөгөөр байгуулбал зохихоос 314,322.4 мянган төгрөгөөр дутуу буюу нийт 4,195,963.4 мянган төгрөгөөр байгуулсан байна.²

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу ангилж активын эрсдэлийн санг бүрэн байгуулах шаарлагатай байна.

ДОЛОО. ДҮГНЭЛТ

1. 2011 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан ирүүлбэл зохих нийт 195 ББСБ-аас 185 ББСБ буюу 94.9 хувь нь тайлангаа ирүүлсэн ба 12 ББСБ буюу 5.1 хувь нь эхлэлтийн санхүүгийн тайлангаар болон өмнөх үеүдийн санхүүгийн тайлангийн дүнгээр хамрагдсан зэргээс үзэхэд тайлангийн ирц сайжирсан байна.
2. ББСБ-уудын дийлэнх хэсэг нь зээл, гадаад валютын үйл ажиллагааг дагнан болон зэрэг эрхлэж байна. Нэр бүхий 29 ББСБ банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрлүүдээс 3-4 –ийг зэрэг эрхлэхээр тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. ББСБ-ын хувь нийлүүлэгчдийн хөрөнгө санхүүгийн чадвараас хамаарч үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх хандлага сул байна.

² Энэхүү тоон үзүүлэлтийг гаргахдаа тухайн ББСБ-уудын ТОП20 зээлдэгчийн мэдээлэлд тулгуурлан гаргасан болно.

Харин гадаадын хөрөнгө оруулалтай болон томоохон банк бус санхүүгийн байгууллагууд нэмэгдэхийн хэрээр банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх факторингийн болон итгэлцэлийн үйл ажиллагаа эрхлэх ББСБ тоо өсөх хандлагатай байна.

3. ББСБ-уудын голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт актив 76,803,284.8 мянган төгрөг буюу 59.7 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 40,918,655.3 мянган төгрөг буюу 52.4 хувь, эзэмшигчийн өмч 46,220,813.4 мянган төгрөг буюу 50.3 хувь, нийт дүрмийн сан 36,505,128.4 мянган төгрөг 45.6 хувиар тус тус өссөн байна.
4. ББСБ-уудын нийт актив 2011 оны жилийн эцсийн байдлаар 205,409,535.1 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт активын **/банкны салбарын нийт актив 9,371,628,345.4 мянган төгрөг/** 2.2 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 119,004,471.9 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт зээлийн **/банкны салбарын нийт зээл 5,597,743,587.3 мянган төгрөг/** 2.1 хувь, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 6,126,039.4 мянган төгрөг байгаа нь банкны салбарын чанаргүй зээлийн **/банкны салбарын чанаргүй зээл 326,857,079.1 мянган төгрөг/** 1.9 хувь, нийт дүрмийн сан 116,519,924.0 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт дүрмийн сангийн **/банкны салбарын нийт дүрмийн сан 264,142,457.8 мянган төгрөг/** 44.1 хувьтай тус тус тэнцэж байна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР